

1912 ОНЫ МОНГОЛ ОРОСЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙН  
ТҮҮХ БИЧЛЭГ

Харнууд З.Лонжид

Монгол улсын их сургууль. Нийгмийн шинжлэх ухааны сургууль. Түүхийн тэнхим

**Өгүүллийн товч утга:** 1912 онд Монгол Оросын хооронд байгуулсан дөрвөн зүйлт хэлэлцээрийн тухай түүхчид хэрхэн судалсан байдлыг эл өгүүлэлд хураангуй авч үзлээ.

**Түлхүүр үг:** Магсар хурц, Дэндэв, Болд, Белов, Чимитдоржиев, Вашингтон, Коростовец.

XX зууны Монгол Оросын харилцааны түүхэнд шууд холбогдох олон сурвалжийн дотор 1912 оны намар Нийслэл Хүрээ гарын үсэг зурсан *"Монгол, Орос хоёр улсын найрамдлын гэрээ"*, *"Хавсарган тогтоосон тусгай гэрээ бичиг"* хэмээх хоёр баримт онцгой учир холбогдолтой. Гэвч эдгээр сурвалжийг эдүгээ хүртэл тусгайлан судалсан бүтээл ховор бололтой. Иймээс би энэ талаар хураангуй өгүүлэл бичсэнээ уншигч эрхэм абугай Танаа толилуулж байна.

Жич: энэхүү баримтын орос хэл дээрхи эхэд *соглашение* гэсэн байдаг бол Монголын түүхэнд *"гэрээ"* *"хэлэлцээр"* *"хэлэлцээ"* хэмээн янз янзаар нэрлэсэн байдаг учир бяцхан тайлбар хэлэх нь зүйтэй мэт Монгол улсын Үндэсний архивт хадгалж буй *"1912 оны Монгол, Орос хоёр улсын найрамдал ба хавсран тогтоосон гэрээ"* гэсэн нэртэй баримт бичиг бол уг хэлэлцээрийн хуулбар юм. Гэтэл энэхүү хэлэлцээрийг Монголын түүхчдийн бүтээлд янз янзаар нэрлэсээр ирлээ. Тухайлбал Магсар хурц *"гэрээ"* (Магсаржав...1994.43) гэсэн бол Ц.Пунцагноров *"хэлэлцээр"* (Пунцагноров...1955.53) 1955 онд хэвлэсэн "БНМАУ-ын түүх"-д *"гэрээ"* (БНМАУ...1955.245) *"хэлэлцээр"* (БНМАУ...1955.263) гэж хоёр янзаар 1968 онд хэвлэсэн "БНМАУ-ын түүх"-ийн хоёрдугаар ботид *"гэрээ"* *"хэлэлцээр"* (БНМАУ...1968.467.468) хэмээн бас хоёр янзаар, 1984 онд хэвлэсэн "БНМАУ-ын түүх" зохиолд мөн л хоёр өөрөөр *"гэрээ"*, *"хэлэлцээр"* (БНМАУ...1984.309.311) гэж бичсэн бол 2003 онд хэвлэсэн "Монгол улсын түүх"-ийн тавдугаар ботид *"хэлэлцээр"* *"гэрээ"* (Монгол...2003. 74, 79, 81) хэмээн бас л хольж бичсэн байна. 2008 онд доктор Р.Болдын хэвлүүлсэн бүтээлд *"хэлэлцээр"* (Болд...2008.42) гэжээ. Уг нь нэг үгээр илэрхийлж тогтвол зүйтэй билээ. Толь бичигт *"соглашение"* гэдгийг *"хэлэлцээр"* (Дамдинсүрэн...1982.663) гэжээ. Гэвч манай түүхэнд "гэрээ" хэмээн бичиж хэвшсэн байна.

Эл хэлэлцээрийн тухай хамгийн анх сөхсөн судлаач бол түүхч Магсар хурц билээ. Гэхдээ тэрбээр уул хэлэлцээрт хэрхэн бэлтгэсэн тухай асуудлыг ер сөхөж тайлбарлаагүй шууд уул хэлэлцээр байгуулсныг дурдаад түүний монгол эхийг хавсаргасан байдаг. Иймд 1912 оны Монгол-Оросын хэлэлцээр байгуулах бэлтгэлийн тухай түүхчид хэрхэн судалсныг харьцуулан авч үзэх нь зүйтэй. Магсар хурц уг хэлэлцээр байгуулагдах гол нөхцөл нь Монгол улсын засгийн газрын илгээсэн цэрэг Хятадын түрэмгий цэрэгтэй амжилттай дайтаж *"Хятадын сөсийг хэмхлэн зүрхийг шантруулж Өвөрмонголын нутаг хийгээд Хятад суурьшсан зарим хотыг эзэлж заримыг эзлэн авахыг завдаж байсан нь.... Орос Улсын зорилгод их л нийлэлцсэн* (Магсаржав...1994.42) учир *"Монгол улс лугаа холбогдох эрх ашгийг яаран олж авахыг хичээж"* (Магсаржав...1994.42) Монголын Засгийн газар зөвлөлдөн найрамдлын гэрээ бичиг байгуулж *"хоёр улс эртнээс янаги харилцан найрамдалтай учир Орос-Монгол хоёрын худалдааг харилцан нэвтрүүлэх журмыг тодорхойгоор илтгэх нь чухал"* (УТА А6-1-536.1) хэмээн шийдвэрлэсэн байна гэж өгүүлжээ.

1934 онд Монголын түүхч Л.Дэндэв энэхүү гэрээний тухай нилээд сонирхолтой зүйлийг өөрийн бүтээлдээ тэмдэглэсэн байдаг. Миний эргэцүүлээр бол Л.Дэндэв



Монгол-Оросын төлөөлөгчдийн хэлэлцээр хийх үед тэмдэглэсэн протоколыг нилээд түлхүү ашигласан мэт. Тухайлбал И.Я.Коростовец Монголын төлөөлөгчидтэй Нийслэл хүрээнд уулзсан анхныхаа ярилцлага дээр *"Их Орос улсын Засгийн газар ба хаан эзэн болбоос Монголчуудын нэгэн итгэлтэй нөхөр мөн"* (Дэндэв...1934. 59), Манай хоёр улсын хооронд одоо байгуулах хэлэлцээр нь *"ирээдүй цагийн Монгол улсын төлөө тус Орос улсаас хамгаалан туслахуйд дөхөм болж өгнө"* (Дэндэв...1934. 60) гэж ярихад Т.Намнансүрэн Т.Цэрэнчимэд нар ихэд баярлаж *"Монголын Засгийн газар бүх монгол үндэстнийг нэгтгэсэн бүрэн эрхт эзэнт улс төр байгуулах явдалд Их Орос улсаас зүйл бүрийн тусламж, дэмжлэг үзүүлэх ба Хятад улсад зөвшөөрүүлэхийг хүсмүй"* (Дэндэв...1934. 64) гэжээ. И.Я.Коростовец үүнд хариу болгож *"Монгол овогтон бүхнийг нэгтгэх явдал болбоос тус улсын зорилго бодлогод харилах бөгөөд гадаад Монгол оортоо эзэрхэх эрхээ урьдаар олж авах нь маш чухал тул үүнийг одоо даруй хэлэлцвээс зохимой"* (Дэндэв...1934.64-65) гэж хариулсанд *"Цэрэнчимэд нараас 1911 онд миний бие Ханддоржийн хамт Оросын Засгийн газар лугаа Монгол овогтныг нэгтгэсэн улс байгуулахыг илэрхийлж тусламжийг эрэхэд Орос улсаас зөвшөөрөн хүлээсэн зүйл буй атал одоо энэхүү санал гаргасныг зөвшөөрч чадахгүй. Хэрэв гадаад Монгол тусгаарлаж дотоод монгол Хятад улсад хэвээр эзлэгдэх аваас үнэхээрийн ашиггүй явдал болно. Энэ учраас Монголын цэрэг нь Хятад лугаа байлдахад гагцхүү Орос улсын тусламжид итгэх бөгөөд тусламж нь бидний хүслийг хангах аваас сая Монгол овогтон бүгдээр нэгдэж нэгэн улс байгуулж чадна. Учир иймд Гадаад Монголын тусгаарлан байгуулах явдлыг Дотоод монголоос салгаж үл болох нь илэрхий болно. Монгол улс нь Орос улсын тусламжийг эхнээс эцэс хүртэл хүлээн авахыг үнэхээр хичээмүй. Энэ тухай бүрэн гүйцэд тусламж хамгааллыг үзүүлэхгүй хэмээвээс Монгол улс нь арга буюу Дундад улсын Засгийн газарт мэдүүлж завсраа хэлэлцэхэд хүрмүй. Тиймийн тул Монгол улсын ирээдүй үесийн тусламж хамгааллыг аль зүгээс эрэх явдал нь энэхүү хурлын шийдвэр лүгээ ихэд холбогдмуй"*. (Дэндэв...1934. 66) гэжээ.

И.Я.Коростовец үүнд дургүйцэж төлөөлөгчдийн анхны хурлыг тараагаад хоёрдахь хуралдаан дээр Оросоос бэлтгэсэн хэлэлцээрийн төслийг танилцуулжээ. Гэвч Монголын төлөөлөгчид тэрхүү төслийг үл зөвшөөрч байгаагаа мэдэгдээд манай Монгол *"Манж-Хятадын захиргаанаас гарч Орос улсын борл албат болохыг үл хүсэх бөгөөд гэрээний хурлыг алгуулж /завсарлаж З.Л./ Бээжин засгийн газраас өөрийн монгол төлөөлөгч ван Наянтыг ирүүлбээс болмой хэмээсэнд Коростовецээс ихэд уурлаж Монголын төлөвлөсөн төлөвлөгөөг шалан дээр хаяж гэрээний хурал хойшилсон гэм учир нь Монгол улсад оногдох бөгөөд тус төлөөлөгч би да ламын гүжир үгүүдийг хүлээж үл чадах учрыг тус улсын хаан эзэн ба Засгийн газарт мэдүүлмүй хэмээж хурлыг"* (Дэндэв...1934.67) тараасан юм. Үүний дараа дараачийн хуралдаан эхлэхэд И.Я.Коростовец мэдэгдэл хийж ДИУ Монголыг довтлохоор илгээсэн их цэрэг Ховд, Алтайн хязгаарт ойртож ирсэн тухай мэдээг манай зохих албаны газруудаас над хэд хэдэн удаа цахилгаан утсаар мэдэгдлээ. Тиймээс та нар тэр их цэргийг *"эсэргүүцэн тулах арга бодлогыг бэлтгэвээс зохино"* (Дэндэв...1934.68) гэсэнд Монголын удирдагчид ихэд айж сандран Орос улсаас зэр зэвсгийн тусламж гуйсанд Коростовецоос *"... найрамдлын гэрээ бичигт үсэг зурахын өмнө ямар ч тусламжийг үзүүлж үл болно. Хэрэв гэрээ бичгийг одоо даруй миний төлөвлөснөөр зөвшөөрөн тогтоох аваас цэрэг зэвсгийн тусламж хамгааллыг үтэр түргэн үзүүлж тэрхүү Хятад цэргийг Монголын хязгаарт оруулахгүй болгохыг миний бие батлан хүлээж авна хэмээсэн учир"* (Дэндэв...1934.68) Монголын төлөөлөгчид тэрхүү хэлэлцээрт гарын үсэг зурсан гэж бичсэн байдаг нь тухайн үед болсон бүх зүйлийг түүхч Л.Дэндэв ямар ч хэтрүүлэлгүй өгүүлсэн бололтой. Үүнийг нотлох ганцхан жишээг өгүүлэхэд И.Я.Коростовец Да ламын саналыг хүлээн авахгүй хэмээн уурлаж *"Монголын засгийн газрын бэлтгэсэн гэрээний төслийг ширээн дээрээс авч шалан дээр хаяад"* (Коростовец...2004.225) Да лам доромжилж буй учир хэлэлцээрийг зогсооно гэж Монгол нөхдөд мэдэгдсэн гэж өөрөө бичсэн байдаг.



Мөн түүнчлэн хэлэлцээр тасалдахад хүрээд байгаа мэдээг Оросын талыг баримтлагч ноёд Богдод айлтгахад тэрбээр өөрийнхөө хатны зөвлөсний дагуу оросуудтай хийж буй хэлэлцээрээ үргэлжлүүл хэмээн Т.Намнансүрэнд зарлиг буулгасан ба Да ламыг миний саналаар түр хассан гэж бичсэн байдаг. (Коростовец...2004.227) Гэвч ийм мэдээг И.Я.Коростовецээс өөр нэг ч хүн тэмдэглээгүй байдаг билээ. Л.Дэндэвийн бичсэнээс үзвэл Г.Цэрэнчимэд Оростой хэлэлцээр хийж тохирохгүй бол ДИУ-тай хэлэлцээр хийнэ гэж мэдэгдсэн аж. Гэвч энэ тухай И.Я.Коростовец ямар ч зүйл дурдсангүй. Харин "Монгол-Хятадын хооронд шууд хэлэлцээр хийхийг Крупенский эсэргүүцэж Хятадууд Монголчуудтай ойлголцож тэднийг Оросын эсрэг хандуулбал Хятадад манай зуучлал ямар ч хэрэгцээгүй болно гэж үзэж байсан бөгөөд Сазонов энэ саналыг дэмжиж манай улс Монголын асуудлаар Хятадтай хэлэлцээр хийх хүртэл Хятад Монголын хэлэлцээрийг эхлүүлж болохгүй гэж байсан билээ. (Коростовец...2004.337) гэж тэмдэглэсэн байдаг. Ингэхээр И.Я.Коростовец Монголтой ямар ч байсан хэлэлцээр байгуулах ёстой хэмээн Засгийн газраасаа өгсөн хатуу даалгаврыг биелүүлэхийн тулд Ховд, Алтайн хязгаар луу Хятадын их цэрэг довтлох гэж байна хэмээн Монголын төлөөлөгчдийг сүрдүүлж байж уул хэлэлцээрт гарын үсэг зуруулсан бололтой.

Одоо цааш нь залгаад 1955 оноос хойш түүхчид Монгол-Оросын хэлэлцээрийн тухай хэрхэн авч үзсэнийг үргэлжлүүлье.

1955 онд хэвлэсэн Монгол улсын түүх зохиолд энэ тухай бичихдээ *"Оросын хаант засаг Юань Шикайн Засгийн газартай хэлэлцээ хийгээд санал хэрхэвч нийлэхгүйг мэдмэгц өөрөө гзлогой мэдэн Монголын автономийг хууль ёсоор зүйтэй гэж үзэж Монголд өөрийн онцгой эрхийг хууль ёсоор тогтоохоор"* (БНМАУ...1955.253) шийдвэрлэж хэлэлцээр байгуулсан хэмээн дурдсан байна. 1955 онд түүхч Ц.Пунцагноров өөрийнхөө нэг сэдэвт зохиолд энэхүү хэлэлцээр байгуулагдах болсон үндсэн шалтгаан нь *"Хаант Орос улс Монголд ноёрхлоо бэхжүүлэхийн тулд Богд гэгээний Засгийн газартай тусгай хэлэлцээ байгуулахаар шийдвэрлэжээ"*. (Пунцагноров...1955.53) хэмээн тэмдэглээд *"Юань Шикай... Богд гэгээнтэй сепарат хэлэлцээр хийхийг оролджээ. Энэ нь Оросын хаант Засгийн газраас Богдтой хэлэлцээр хийх шалтаг болов"* (Пунцагноров...1955.53) гэж тайлбарлажээ. 1966 онд хэвлэсэн "БНМАУ-ын түүх" зохиолд энэ тухай бичихдээ 1955 онд БНМАУ-ын түүх зохиолд тэмдэглэсэн зүйлийг хэвээр нь хуулбарласан (БНМАУ...1966.245) бол 1968 онд үүнийг арай дэлгэрүүлж *"Орос улс Монгол улстай шинэ гэрээ байгуулах замаар улам илүү эрх олж авах гэсэн"* (БНМАУ...1968.466) зорилгоор 1912 оны наймдугаар сарын 15-нд Хаант Оросын сайд Нарын зөвлөл *"хүрээний хутагт ба халхын ноёдтой байгуулах гэрээний тухай"* асуудлыг анх авч ... хэлэлцсэн" (БНМАУ...1968.466) юм. Ингээд *"Монголын асуудлаар азнах бодлого улам бүр аюултай болсоор байх бөгөөд үүнийг одоо даруй нэгэн тийш болгох сайн арга шийдвэр гэвэл Орос Халхын хооронд дипломат гэрээ байгуулах явдал мөн"* (БНМАУ...1968.466) гэсэн шийдвэр гаргасан байна. Тэгэхдээ энэхүү хэлэлцээр байгуулахдаа *"Халхын ёс журмыг"* хэвээр хадгалан байлгахыг манай Орос улс амлан харин *"дотоод Монгол ба Баргаас хүрээний газарт дагаар орох тухай зарлан тунхагласан зарим зүйлийг одоохон дээрээ уг хэлэлцээрийн гадна орхих"* (БНМАУ...1968.467) нь зүйтэй гэж уг хурал анхааруулжээ хэмээн Орос улс Монголтой гэрээ байгуулах болсон гол шалтгааныг урьд өмнөх судлаачдын бүтээлд ер тэмдэглээгүй шинэ санаагаар тодруулж өгсөн байна.

Үүнээс гадна Монголын Засгийн газар ч хаант Орос улс бол тэр үеийн томоохон гүрнүүдийн нэг түүнтэй *"дипломат хэлэлцээр хийж гэрээ байгуулах нь"* (БНМАУ...1968.466) *"дэлхийн олон улсын харилцааны тавцан дээр Монгол улс биеэ даан гарч ирсний бас нэг том"* нотолгоо болох байв. Иймээс *"энэ бололцоог Богд гэгээний Засгийн газар өөрийн гадаад бодлогодоо хир чадлаараа ашиглахыг оролджээ"* (БНМАУ...1968.466) хэмээн тэрхүү гэрээ байгуулахад Монголын тал нилээд нааштай



хандаж байсныг заан тэмдэглэжээ. Энэ бол 1912 оны Монгол, Оросын гэрээний талаарх судалгаанд гарсан шинэ ахиц байлаа.

Мөн Монголын сайдууд Оросын тулгаж буй хэлэлцээрийн төслийг огтхон ч зөвшөөрөхгүй байсныг И.Я.Коростовец хичнээн сүрдүүлээд ч нэмэргүйг ойлгож эцэст нь арга заль зохиож Монголын тэргүүн сайдуудыг Орос консулын газраа урин авчирч танай Монголыг довтлон дайлахаар Хятадын их цэрэг баруун хязгаарын Ховд, Алтай замын чигт ойртож ирснийг манай хязгаар захын албан газар бидэнд нааш мэдэгдэв. Тэр Хятад цэргийн тоо тоолж баршгүй, зэр зэвсэг хурц гэнэ. Та бүхэн тулалдах арга эртхэн бодвол зохино гэсэнд монгол сайдуудын царай барайн их л самгарджээ. Сайн ноён хан тэр дороо И.Я.Коростовецээс туслахыг гуйхад тэрбээр *"хоёр улсын найрамдлын гэрээнд гарын үсэг зурахаас нааш тусламжийн тухай ямар нэг яриа байж болохгүй"* (БНМАУ...1968.468) хэмээн 1968 онд хэвлэсэн "БНМАУ-ын түүх"-ийн хоёрдугаар ботид И.Я.Коростовец Монголын эрх баригчдыг айлган сүрдүүлж өөрийнхөө түрэмгий шинжтэй хэлэлцээрийн төслөө Монголын удирдагчдаар зөвшөөрүүлж чадсан тухай анх удаа өгүүлжээ.

1984 онд хэвлэсэн Монголын түүхийн нэг боть зохиолд энэ тухай ер өгүүлсэнгүй. Гэхдээ урьд өмнө нь төдий л дурдаж байгаагүй өөр санал дэвшүүлсэн юм. Түүний гол агуулга нь гэвэл Орос улс Манж чин гүрний улс төрийн хүнд байдлыг ашиглаж 1911 оны арваннэгдүгээр сард Бээжинд хандаж *"Монголыг Хятадын харъяанд оруулан гагцхүү дотоодод нь өргөн автономит эрхтэй болгох тухай албан ёсны гэрээг халх Монголыг байгуулна уу гэж санал гаргажээ"* (БНМАУ...1984.309) үүнээс гадна Хаант Орос өөрөө Монголд онцгой эрхтэй байхаа Манжаас албан ёсоор тулган шаардаж *"аливаа хэргийг өөртэй нь хамаарахгүйгээр шийдвэрлэж байх явдлаас татгалзахыг шаардсан"* (БНМАУ...1984.309) байна. Манжийн төр унасны дараа Хаант Орос улс ДИУ-ын *"Засгийн газартай гадаад Монголын талаар хэлэлцээ хийж эхлээд тэр нь 1912 оны турш үргэлжилсэн боловч үр дүнд хүрсэнгүй. Хятадын түшмэд, худалдаачин, мөнгө хүүлэгчид Юань Ши Кайн Засгийн газарт Оросын өнгөлзлөгийг эрс няцаахыг шаарджээ"* (БНМАУ...1984.309) үүнээс гадна ДИУ-ын *"Засгийн газар Монголыг Хятадаас тусгаарлахыг зөвшөөрсөнгүй тэрчлэн Монголд дотоодын өргөн автономит эрх олгох гэсэн Хаант Оросын саналыг няцаав"* Ингэж Орос улс ДИУ-ын Засгийн газартай *"хэлэлцээ хийж санал хэрхэвч нийлэхгүйгээ мэдмэгц Монголыг автономит эрхтэй болгож тус оронд өөрийн зонхилох байр сууриа албан ёсоор бататгахын тулд дангаар жич арга хэмжээ авч Монголтой гэрээ байгуулсан юм"* гэж тайлбарласан байна.

Жич, энэхүү хэлэлцээрийн тухай академич Б.Ширэндэв 1971 онд хэвлүүлсэн нэгэн томоохон бүтээлдээ хөндөж *"Монголын тухай хийх Орос-Хятадын хэлэлцээрийг бэлтгэхийн тулд Хаант Оросын Засгийн газар нь Монгол улстай жич хэлэлцээр хийж байв"* (Ширэндэв...1971.34) гэж бичжээ. Академич Б.Ширэндэв аругай ингэж бичсэнээ тодруулан тайлбарласангүй. Мөн чухам ямар сурвалжид тулгуурлаж ийм сонирхолтой санаа дэвшүүлсэнээ дурдаагүй байна. 1999 онд уул зохиолоо дахин хэвлүүлэхдээ мөн хэвээр нь үлдээсэн байлаа. Монголын түүхчид 1925 оноос 1984 он хүртэлх бүтэн жаран жилийн хугацаанд Монгол Оросын 1912 оны гэрээний тухай ерөнхийдээ төстэй боловч бага зэрэг ялгаатай санал дэвшүүлж дүгнэлт хийсээр байсан бөгөөд 2003 онд хэвлүүлсэн томоохон бүтээлд уг гэрээ байгуулах болсон чухам шалтгааны тухай төдий л дурдсангүй. *"Харин Оросын хаан 1912 оны эхээр элчин сайдаараа дамжуулан найрамдлын гэрээ бичиг байгуулж хоёр улс үүрд сайнаар найрамдан ард хүн нар уртдаа энх түвшин жаргасугай хэмээн Жибзундамбад талархал, итгэл найдвараа илэрхийлсэн юм"* (Монгол...2003.73) гэж бичжээ. Тодруулж хэлбэл Хаант Орос улс эзэн хааныхаа саналын дагууд л 1912 онд Монголтой хэлэлцээр байгуулсан гэсэн санаа гаргажээ. Гэвч энэ нь тухайн үеийн бодит байдалтай төдий л нийцэхгүй байгаа юм. Яагаад гэвэл Хаант Орос эхлээд ДИУ-тай Монголын тухай асуудлаар хэлэлцэж харилцан тохиролцох байр суурьтай байсан боловч Хятадууд Хаант Оросын саналыг огт хүлээж авахгүй байсны улмаас байдал хаашаа ч эргэж болзошгүйг ухаарсан Орос улс ямар ч байсан Монголтой



### III. МОНГОЛЫН ТҮҮХ БИЧЛЭГИЙН АСУУДЛУУД

тохиролцож албан ёсны гэрээ байгуулж баталгаажуулахын тулд уг гэрээ байгуулах асуудал шийдэгдсэн нь маргаангүй гэж би үзэж байна.

1912 оны Монгол-Оросын хэлэлцээрийн тухай асуудал бол XX зууны Монголын түүх, ялангуяа Монгол-Оросын улс төрийн харилцааны түүхэнд заавал авч үзэх ёстой сэдэв учраас түүхчид энэ талаар өөрсдийн бүтээлд олонтоо хөнддөг. Тийм бүтээлийн нэг бол акад. Б.Лхамсүрэнгийн 1995 онд хэвлүүлсэн нэг сэдэвт зохиол юм. Тэрбээр дээрх хэлэлцээрийн тухай хөндөж бичихдээ бусад судлаачдын санал дүгнэлтийг ерөнхийд нь давтсан боловч Хаант Орос *"бүх монгол овогтонг нэгтгэх явдал Орос улсын засгийн бодлогод хариллах бөгөөд Гадаад Монгол өөртөө эзэрхэг эрхээ урьдаар олж авах нь чухал гэдэг байр суурь барьж түүнийг зөвшөөрөх явдлыг гаднындовтолгооноос хамгаалахад Орос улсаас тусламж үзүүлэх урьдчилсан нөхцөл болгон тулгажээ"*. (Лхамсүрэн...1995.13) хэмээсэн шинэлэг санаа дэвшүүлжээ.

1912 онд Монгол-Оросын хооронд байгуулсан хэлэлцээрийн тухай олон судлаач бичсэн боловч ерөнхийдөө төстэй бөгөөд хэдхэн зүйлийг давтан өгүүлээд тодорхой дүгнэлт хийхээс зайлсхийж байсан бол 1999 онд академич Б.Балдоо энэ асуудлаар бичсэн зохиолдоо урьд өмнөх судлаачдын бүтээлд төдий л дэвшүүлж байгаагүй шинэ бөгөөд үнэмшилтэй сонирхол татахуйц дүгнэлт хийсэн юм. Акад Балдоо энэхүү хэлэлцээрийн тухай авч үзэхдээ зайлшгүй анхаарах ёстой баримт буюу эх хэрэглэхүүнээ оновчтой сонгож чадсанаараа өмнөх судлаачдаас илүү давамгайл байжээ. Түүхч А.Ж.Тойнби *"баримт бол түүхийн амьд цогцос"* (Тойнби...2007.471) хэмээн онож тодорхойлсоныг Балдоо академич Монгол Оросын улс төрийн харилцааны түүхийг нэхэн шинжилсэн бүтээлдээ тууштай баримталжээ.

Ингээд акад.Балдоогийн бичсэнийг хураангуй авч үзье. Тэрбээр уг хэлэлцээр байгуулах санаачлага чухам хэзээ хэдийд эхэлснийг тодруулжээ. Түүний бичсэнээс үзвэл, 1912 оны эхээр Орос Улс Засгийн газрынхаа гадаад бодлогын зорилт, байр суурийг албан ёсоор тодорхойлоход Орос Улс монголын тухайд хэрхэн холбогдох асуудал анх хөндөгдсөн байна. Тус хуралдаан дээр шинэ тутам байгуулагдсан ДИУ-ын *"Засгийн газрыг зөвшөөрөн хүлээх нөхцлүүдийн дотор Монголын асуудлын шийдвэрлэлтийг оруулж"* (Балдоо...1999.15) энэ тухайгаа эзэн хаандаа илтгэх хуудас өргөж зөвшөөрөл авсан бөгөөд энэ баримт бичигт Монголын асуудлыг Хятад Улс Оросын оролцоогүйгээр шийдвэрлэж чадахгүйг тэмдэглэж энэ талаар цаашид чармайлт тавихын чухлыг дурджээ. (Балдоо...1999.15) Үүнээс хойш мөн оны дөрөвдүгээр сарын 13-нд Улсын Думын хуралдаан болж Оросоос Монголын тухайд баримтлах бодлогыг хэлэлцэхэд эсрэг тэсрэг хоёр санал гарч Гадаад хэргийн сайд С.Д.Сазонов, Дум дахь кадет бүлгийн удирдагч П.Н.Милюков нар *"Монголын хэрэгт хутгалдан оролцохын эсрэг Монгол-Хятадын хооронд зуучлах үүрэг гүйцэтгэхийн төлөө"* саналтай байв. Гэтэл Думын зарим гишүүд *"Монголыг шууд Орост нийлүүлэх"* саналтай байв. Гэвч удтал хэлэлцээний эцэст С.Д.Сазонов нарын саналыг зөвшөөрч *"Монгол-Хятадын хооронд зуучлах үүрэг гүйцэтгэн уг асуудлыг зохицуулах"*-аар шийдвэрлэсэн байна. Энэ нь 1911 онд М.Ханддорж нарыг Орост очсоны дараа Монголын асуудлаар болсон Засгийн газрын тусгай зөвлөлгөөний дүгнэлттэй үндсэндээ тохирч байжээ.

Оросын Засгийн газар Улсын Думын шийдвэрийн дагуу Монголын асуудлыг шийдвэрлэхээр зуучийн үүрэг гүйцэтгэн шургуу ажиллаж байсан тухай акад. Б.Балдоо өгүүлээд үүнийгээ тодорхой баримтаар нотложээ. Түүнээс үзвэл Бээжин дэх Оросын дипломат төлөөлөгчийг түр хамаарагч 1912 оны гуравдугаар сарын дундуур ДИУ-ын ерөнхийлөгчтэй уулзаж Монголд автономит эрх олгох талаар Орос, Хятад, Монголын хоорондын тохиролцоог аль болохоор хурдавчлах, монголчуудын дунд гарсан хөдөлгөөнийг хүчээр дарахад үл хүргэхийг сануулан дурдахад ДИУ-ын ерөнхийлөгч Монголын асуудлаар Оростой хэлэлцээр байгуулах явдал ганц надаас хамаарахгүй удахгүй Сайд нарын Зөвлөлийн дарга, сайд нар Бээжинд цуглахад асуудлыг хэлэлцүүлж хариу мэдэгдэнэ гэжээ.



Үүний дараа мөн оны дөрөвдүгээр сард Оросын шинэ элчин ДИУ-ын ерөнхийлөгчид бараалхахдаа энэ талаар ярилцахад тэрбээр хариу хэлэхдээ манай сайд нар цугларсан удахгүй хэлэлцэнэ гэжээ. Чингээд ДИУ-ын Засгийн газар Оросын дэвшүүлсэн гурван зүйлт саналыг хэлэлцэхэд Сангийн яамны сайд Сюн Силин: Оростой нэн даруй хэлэлцээ хийж Орос Монголын хооронд шууд гэрээ хэлэлцээр байгуулахаас татгалзах нь чухал гэсэн бол Гадаад хэргийн сайд Лү Чжэнь Сян Ар Монгол бол Хятадын нутаг тул Хятад Монголын хооронд явагдах хэлэлцээнд орос хүн оролцуулж болохгүй ёс бусаар санаархаж байгаа учраас Оростой хэлэлцээ хийхгүй гэж тогтох нь зүйтэй гэсэн байр суурь баримталж байв. Тиймээс ч 1912 оны зургадугаар сарын 19-нд ДИУ-ын Гадаад хэргийн сайд Бээжин дэх Оросын элчин төлөөлөгчид: Хятад улс Монголын асуудалд танай улс ямар ч байдлаар оролцохыг үл хэрэгсэхээр бэлтгэж байна. Ер нь яагаад Монголын асуудал Орос Хятадын хооронд явагдах хэлэлцээний зүйл болсныг ойлгохгүй байна гэжээ. Ингэж ДИУ Монголын асуудлыг Хятадын засгийн газар цаашид шийдвэрлэхдээ Оросын зуучлалыг авах хүсэлгүй гэдгээ Оросын элчинд ойлгуулсныг академич Б.Балдоо Монголын түүх бичлэгт анх удаа тодруулжээ.

Үүний дараа Орос Улс Монголтой гэрээ байгуулах яриа гарахыг мэдсэн ДИУ Оросын байр суурийг тандах зорилгоор Оросуудтай Монголын асуудлыг шийдвэрлэх талаар бас санал солилцож байсан гэж акад. Б.Балдоо тэмдэглээд үүнийгээ зохих сурвалжаар нотолсон байна. Ингэж Хятад, Оросын дипломатуудын хооронд Монголын тухай яриа үргэлжилж байх явцад Орос Улс Монголтой гэрээ хийхээр шийдвэрлэснээр хоёр улсын хэлэлцээ эхэлж хамтарсан дипломат баримт бичиг боловсруулан гаргах боломж бүрдсэн байна гэж дүгнэжээ.

Акад. Б.Балдоо уул хэлэлцээрийн ач холбогдлыг мөн шинэ байдлаар дүгнэсэн байдаг. Тэрбээр бичихдээ *"Энэхүү гэрээ нь тунхаглаад нэг жил шахсан Монгол Улсаас олон улсын харилцаанд эзлэх статусыг тодорхойлоход хууль эрхийн анхны бодитой алхам хийсэн баримт бичиг болжээ. Энэ хэлэлцээрээр 1.Монгол бол эзэн хаантай, Засгийн газартай улс мөн, 2.Тэр нь өөрийн улсын цэрэг байгуулах эрхтэй, 3. Тэр нь "Өөртөө тогтнож, өөрөө эзэрхэх" ёс журамтай, 4. Тэр нь өөрийн нутгаас Хятадын цэрэг ба эрх баригчдыг үлдэн гаргасан бөгөөд дахин өөрийн газарт Хятадын цэрэг ба нүүдлийн иргэдийг үл оруулах эрхтэй, 5. Тэр нь Хятад болон бусад гадаад улстай хэлэлцээ хийж өөр гэрээ байгуулах эрх бүхий этгээд мөн гэдгийг Орос Улсын Засгийн газар хүлээн зөвшөөрч эдгээрийг "алдагдалгүй сахихад" цом тусална гэж Орос Улс өөртөө амлалт үүрэг авсан байна"* (Балдоо...1999.21) гэж уг гэрээний ач холбогдлыг нилээд үнэмшилтэй дүгнэсэн юм.

Акад.Б.Балдоогийн бичсэн энэ шинэ санаа дүгнэлтийг манай судлаачид төдий л хайхрахгүй байгааг 2003 онд хэвлэсэн "Монгол Улсын түүх" зохиолын тавдугаар ботиор нотлож болно. Тодруулж хэлбэл 1999 онд акад. Б.Балдоогийн хийсэн энэ дүгнэлтийг уул номд ер тусгаагүй байна. (Монгол...2003.18 дахь талд үз)

Дээрх хэлэлцээрийн тухай хөндсөн бас нэг бүтээл бол 2005 онд доктор О.Батсайханы хэвлүүлсэн нэг сэдэвт зохиол юм. Энэ номын зохиогч ОХУ-ын монголч эрдэмтэн Е.А.Белов ба акад. Б.Балдоо нарын бүтээлд голлон тулгуурлаж уул гэрээний тухай өөрийн бодол эргэцүүлээ тайлбарлажээ. Тэрбээр уул гэрээ байгуулах саналыг анх дэвшүүлсэн хүн бол Бээжин дэх Оросын элчин байсан бөгөөд Оросын тадаад хэргийн яам уг саналыг *"нааштай хүлээн авч Орос-халхын хооронд байгуулж болох хэлэлцээрийн төслийг боловсруулан Засгийн газраар хэлэлцэж эзэн хаан хоёрдугаар Николайд танилцуулахад "Яаравчлах хэрэгтэй" хэмээн тэрбээр цохжээ"* (Батсайхан...2005.74). Энэ дагууд 1912 оны наймдугаар сарын 2-нд Оросын сайд нарын зөвлөл тусгай хуралдаанаар хэлэлцэж Гадаад яамны сайдын саналаар Монголын асуудлаар Хятадтай явуулж буй хэлэлцээг тасалж хүрээтэй нууц хэлэлцээг эхлэх шийдвэр гаргажээ (Батсайхан...2005.90) гэжээ. Мөн түүнчлэн Хаант Оросын /гадаад хэргийн яам Монголтой байгуулах хэлэлцээрийн тухай 1912 оны наймдугаар сарын 23-нд Оросын бүрэн эрх барих



төлөөлөгч И.Я.Коростовецид заавар өгч юуны өмнө уг хэлэлцээр байгуулах болсон учрыг тайлбарлаж Орос улс Монголын асуудлаар Хятадтай хэлэлцээд ямар нэгэн мэдэгдэхүйц үр дүнд хүрсэнгүй. Энэ нь хятадууд Монголын тусгаар тогтнолыг хүчээр устгах зорилгоор Монголын ноёдын дунд яс хаях, монголд цэргийн ангиудыг явуулах зэрэг үйл ажиллагаатай холбоотой. Үүнээс үндэслэн Орос улс Монгол дахь байдал өөрчлөгдсөнийг үл харгалзагч Хятадуудтай хэлэлцээ хийх боломжгүй боллоо. Иймд Оросын Засгийн газар хүрээний Засгийн газартай шууд харилцах замд орж түүнтэй хэлэлцээр байгуулахаар шийдвэрлэлээ. Үүний үндсэн зорилго нь *"Халхын автономийг батлах нөхцөлийг бүрдүүлэх явдал мөн гэж заасан байна"* (Батсайхан...2005.76) гэж өгүүлжээ. О.Батсайхан уул хэлэлцээрт Орос улс гурван болзол тусгасныг хураангуйлан дурдсан юм. Үүнд: 1-рт Халхад үндэсний эрхийг олгох 2-рт Монголд Хятад цэргийг оруулахгүй байх 3-рт халхыг хятадуудаар колоничлуулахгүй байхад чиглэжээ. (Батсайхан...2005.20).

Оросын энэ болзол нь *"Монголын Хятадаас тусгаар тогтнох асуудал Оросуудын ашиг сонирхолд ямар нэгэн хэмжээгээр нийцэж байсан хэмээн үзэж болох бөгөөд өрнөл ч үүнийг давхар нотолдог"* (Батсайхан...2005.20) гэж дүгнэсэн байна.

2008 онд доктор Р.Болдын хэвлүүлсэн бүтээлд энэхүү хэлэлцээрийн тухай өгүүлсэн зүйл хэдийгээр хураангуй боловч хэд хэдэн шинэ мэдээллийг судлаачдад хүргэсэн юм. Тухайлбал хаант Оросын засгийн газар Бээжинд сууж буй элчин сайдаараа дамжуулан 1912 оны арваннэгдүгээр сарын найманд уул хэлэлцээрийг хүлээн зөвшөөр хэмээн ДИУ-аас шаардсан бөгөөд үүнийг тус улсын Засгийн газар мөн сарын арванхоёрны өдөр хуралдаанаараа хэлэлцэхэд ГЯЯ-ны сайд нь *"Орост хүчтэй эсэргүүцэл илэрхийлэх"* санал гаргасныг бусад сайд нар нь хүлээн авсангүй харин монгол оросын хэлэлцээрийг хүчингүй болгох, харилцан буулт хийсэн зөвшилцөлд хүрэх яриа хэлэлцээ хийхийг санал болгосон ба ийм зөрөлдөөний улмаас Хятадын ГЯЯ-ны сайд огорчээ. Гэвч мөн сарын 13-нд ДИУ-ын парламентын хуралдаан болж Монгол Оросын хэлэлцээрийн тухай хэлэлцээд долоон зүйлтэй шийдвэр гаргасны дотор Монголын тусгаар тогтнол, автономийн алиныг ч зөвшөөрөхгүйгээ Орос улсад эрс шийдэмгий илэрхийлэх Богд бол зөвхөн шашины тэргүүн учир улс төрийн эрх мэдэлгүй тул түүний байгуулсан Монгол Оросын хэлэлцээрийг нэн даруй цуцлах, Богдыг баривчилж шийтгэх, уул хэлэлцээрийг Хятад улс хүчингүй хэмээн үзэж байгаагаа гадаад гүрнүүдэд мэдэгдэх, монголыг буцааж өөртөө нэгтгэхийн тулд цэргийн хүч илгээх, хэрэв Орос улс Монгол Хятадын хооронд зуучлахыг оролдвол дайн зарлах зэргийг цохон тэмдэглэжээ.

Хятадын парламентын энэхүү шийдвэрийг АНУ-аас Бээжинд сууж байсан элчин сайд 1912 оны арваннэгдүгээр сарын 19-нд Вашингтонд мэдэгдсэн байжээ. (Болд...2008.42-т үз) Р.Болдын бичсэн энэ мэдээ бол урьд өмнө нь манай судлаачдын сонорт төдий л хүрч байгаагүй учраас 1912 оны дээрхи хэлэлцээрийн тухай судалгаанд зохих тус дөхөм болж буйг талархан тэмдэглэе.

1912 оны энэхүү хэлэлцээр нь XX зууны Монгол Оросын улс төрийн харилцааны түүхийн эхэн үед холбогдох нэн чухал үйл явдал болсон учраас ОХУ-ын эрдэмтэд өөрсдийн бүтээлдээ уг гэрээний тухай урьд өмнө нь хааяа хөндөн өгүүлж байсан бол сүүлийн үед нилээд идэвхжсэн юм. Иймээс энэ талаар товч өгүүлбэ.

1959 онд судлаач М.В.Мещеряков нэгэн бүтээлдээ мөнөөх гэрээний тухай цухас дурдахдаа энэхүү хэлэлцээрээр Оросын худалдаачид Монголын бүх нутгаар чөлөөтэй зорчиж монголчуудад ямар ч татвар хураамж төлөхгүйгээр тус улсад худалдаа эрхэлж зээлийн гэрээ хэлцэл байгуулах ба байгалийн баялаг ашиглах эрх олж авсан юм (Мещеряков...1959.29). Оросын Засгийн газар үүний хариуд төмөр замын тарифаа багасгаж 1914 онд Монголын таваарыг Орост гаалийн хураамжгүй оруулахыг зөвшөөрсөн гэжээ. (Мещеряков...1959.29) Үүнээс үзвэл Монгол улс 1914 оноос эхлэн гааль төлөхгүйгээр бүтээгдэхүүнээ Орос руу экспортлох эрхтэй болсон мэт. Гэвч тэрбээр үүнийгээ ямар ч баримтаар нотлосонгүй. Миний бодоход энэ бол илэрхий ташаа зүйл бөгөөд тухайн үеийн баттай сурвалжаар нотлож болно. Жич тэмдэглэхэд энэхүү



хэлэлцээрт гарын үсэг зурсны дараахан И.Я.Коростовец Монголын Засгийн Газарт тусгай нот бичиг ирүүлж зөвхөн Хиагтын баруун хилээр Орос руу нэвтрүүлэх зүйлээс гааль хураахгүйгээ манай Засгийн газар нотоллоо хэмээн мэдэгдсэн байдгийг ард тайлбарласныг үзээрэй.

Дээрх хэлэлцээрийн тухай доктор проф Ш.Б.Чимитдоржиев 1987 онд бичихдээ уг хэлэлцээрт Хаант Орос улс 1912 оны дөрөвдүгээр сараас бэлтгэж эхэлсэн гэж тэмдэглээд Нийслэл хүрээнд мөн оны ес аравдугаар сард Монгол Оросын төлөөлөгчид уг хэлэлцээрийн тухай хэлэлцэхэд нэлээд хурц маргаан гарч байв. Тухайлбал Гадаад монголын тусгаар тогтнол ба Өвөр монгол, Баргыг Монголд нэгтгэж нэгдсэн Монгол Улс байгуулах тухай асуудлаар Орос Монголын тал харилцан адилгүй байр суурьтай байсан учраас үзэл бодол зөрчилдөж байв хэмээн тэмдэглэсний сацуу урьд өмнө нь түүхчдийн ер хөндөж байгаагүй нэгэн асуудлыг шинээр мэдээлж судлаачдын анхааралд хүргэсэн юм. Тэр нь юу вэ гэвэл Монголын төлөөлөгчийг Петербурgt суулгах тухай асуудал байлаа (Чимитдоржиев...1987.143) Тэрхүү ширүүн маргаанаас болж хэлэлцээ арай л тасалдаагүй бөгөөд И.Я. Коростовец нэг удаа хуралдааны танхимыг орхин гарч байсан ба 1912 оны аравдугаар сарын 5-нд Петербурgt бичихдээ *"Орос улсад дайсагнагч Да лам, Шанзудба ба бусад зарим сайд нарын ухуулгын уршгаар сүүлийн үед хэлэлцээр нилээд хүйтэрч Хятадтай ойртох ашигтай байдал бий болж буй нь над сайтар мэдэгдэж байна"* (Чимитдоржиев...1987.143).

Монголын ноёд Монголын бүрэн тусгаар тогтнолыг тулгаж энэхүү гэрээгээр Өвөр Монгол Баргыг нэгдсэн Монгол Улсын бүрэлдэхүүн хэсэг гэж яг таг тодорхойлох хэрэгтэй хэмээн шаардаж байв. Хаант Оросын төлөөлөгч эдгээр шаардлагыг эсэргүүцээр байсан боловч зөвхөн ганц зүйл дээр л буулт хийсэн юм. Тэр нь юу байсан бэ гэвэл хэлэлцээрийн нэрэнд *"Гадаад Монгол"* гэдэг үгийг *"Монгол Улс"* хэмээсэн үгээр сольсон юм. Петербурgt Монголын төлөөлөгч суулгах тухай асуудлыг шийдвэрлээгүй юм. Бүхэлдээ энэхүү гэрээгээр Орос улс Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөөгүй юм гээд уг гэрээний агуулгыг тайлбарлажээ. -

Үүнээс гадна Ш.Б.Чимитдоржиев уг гэрээний улс төрийн ач холбогдлыг дүгнэж бичихдээ Монголын Засгийн газар том бөгөөд нөлөөтэй Хаант Оростой гэрээ байгуулсан нь Монголыг дэлхийн тайзан дээр гаргаж өгсөн юм. *"Орос улс Монголтой олон улсын гэрээ хэлэлцээрийн харилцаа тогтоосноор түүний оршин буйг дэлхий дахины өмнө хүлээсэн хэрэг боллоо"* (Чимитдоржиев...1987.144) гэж дүгнэжээ.

Энэхүү хэлэлцээр байгуулсны дараа Монголын асуудлаар дипломат эсэргүүцэл эрчимтэй өрнөсөн тухай Ш.Б.Чимитдоржиев тодорхой өгүүлсэн юм. Тухайлбал Хятадын төлөөлөгчид мэдэгдэхдээ Монгол бол ДИУ-ын бүрэлдэхүүн хэсэг учраас гадаад улсуудтай хэлэлцээр байгуулах эрхгүй, иймээс Монгол-Оросын гэрээг хүчингүй болгох ёстой хэмээн сүрдүүлж байв. Үүний хариуд Оросын төлөөлөгч энэхүү гэрээнд гарын үсэг зурах болсон нь бидэнтэй хамт Монголын асуудлыг шийдвэрлэе гэхэд эрс эсэргүүцэж байсан Хятадын Засгийн газрын үйл ажиллагаатай холбоотой. Бий болсон байдлаас түргэн гарах арга бол монголчуудыг оролцуулсан Орос Хятадын гэрээ байгуулах явдал гэсэн саналыг Оросын Засгийн газар дэвшүүлсэн боловч Хятадын тал няцаан тууштай эсэргүүцээр байв. Хятадын харгис хүчнүүд үймээн дэгдээсэн монголчуудыг чанд хатуу шийтгэхийг шаардаж улс төрийн янз бүрийн намууд Бээжин, Шанхай, Кантонд зөвлөлгөөн хийж дайсагнасан шинжтэй тогтоол баталж янз бүрийн мужуудаас мөн иймэрхүү санааг илэрхийлсэн цахилгаан утас хүлээн авч байсан ба Хятадын хэвлэлүүд ч ийм байдлыг дэвэргэн хөөрөгдөж байсан ба Засгийн газрын зарим гишүүд үүнийг нь магтан урамшуулж байсныг Оросын элчин төлөөлөгч И.Н.Крупенский мэдээлж байжээ.

Үүнээс гадна Шинжианы амбан сайд их хэмжээний цэрэг баруун монгол руу илгээж Орос, Монголыг заналхийлж байв. Үүний улмаас Хаант Оросын Засгийн газар 1913 оны зун Ховдын хязгаарт цэрэг оруулсан байна. Гэхдээ орос улс Өвөр Монгол ба Барга руу хятад цэрэг илгээхийг болон эдгээр нутагт хэрцгий харгислал үйлдэхийг урьдчилан



### III. МОНГОЛЫН ТҮҮХ БИЧЛЭГИЙН АСУУДЛУУД

сэргийлж чадаагүй юм гэж Ш.Б.Чимитдоржиев тэрхүү гэрээний дараах Хятадын байдлыг тодорхой бичжээ.

Мөн түүнчлэн өрнөдийн гүрнүүд Монгол дахь Орос улсын байр суурь бэхэжвэл өөрсдөд нь аюултай хэмээн Монгол-Оросын хэлэлцээрт эрс үгүйсгэсэн байдлаар хандаж байв гэж тэрбээр тэмдэглэсэн байна. Мөн уул хэлэлцээрт болон Орос Хятадын дипломат яриа эхэлж байгаа явдалд Монголын хар шар ихэс дээдэс цөөнгүй хүн дургүйцэх боллоо. Хаант засаг Монголын бүрэн тусгаар тогтнол ба бүх монголчууд нэгдэхэд нөлөөлж чадаагүйд дургүйцсэн олон хүн тэдний дунд байлаа. Тиймээс ч нөлөө бүхий ихэс дээдэс Японтой ойртох буюу бие дааж Хятадтай тохиролцохыг хичээн чармайх болов. Уг гэрээнд гарын үсэг зурмагц Богд гэгээн Японы эзэн хаанд нөхөрсөг захидал хүргүүлэхээр өөрийнхөө Засгийн газрын Дотоод хэргийн сайд Да лам Цэрэнчимэдийг Японд илгээв. Гэвч Манжуур Монгол дахь нөлөөний хүрээгээ Хаант оростой тохиролцож хэлэлцээр байгуулсан Япон улс Оростой харилцаагаа муутгахыг хүсээгүй учир Цэрэнчимэдийг Хайлараас цааш явуулаагүй юм (Чимитдоржиев...1987.145-146) гэж дээрх гэрээний тухай нилээд дэлгэрэнгүй бөгөөд тодорхой өгүүлжээ. Мөн тэрбээр Монгол-Оросын энэхүү хэлэлцээр өрнөдийн орнуудад төдийлөн таалагдаагүй бөгөөд) хаант Орос Монголд байр сууриа бэхжүүлсэн нь бусад улсуудад аюултай хэмээн тэд үзэж байсан юм гэж Ш.Б.Чимитдоржиев дүгнэсэн юм. (Чимитдоржиев...1987.145) Ингэж 1912 оны Монгол-Оросын хэлэлцээрийг түүх бичлэгт анх удаа хөндөж зохих дүгнэлт өгөх гарааг доктор проф Ш.Б.Чимитдоржиев эхлүүлсэн билээ.

Дээрх асуудлыг цааш нь улам тодруулан судалсан эрдэмтдийн нэг бол Е.А.Белов юм.Тэрбээр ОХУ-ын олон архивын баримт бичгийг сайтар судлаж Орос Монголын харилцааны 1911-1919 оны үеийн тусгайлан судалсан бүтээлээ 1997 онд бичиж дуусгаад хоёр жилийн дараа хэвлүүлсэн бүтээлдээ дээр дурдсан гэрээний тухай авч үзсэн юм. Тэгэхдээ Оросын эрх баригч бүлэг ба либераль сэхээтний төлөөлөгчид Монголыг тусгаар тогтносон улс болоход Орос туслах нь зүйтэй хэмээн үзэж байсныг тодорхой баримтаар өгүүлжээ. Тэрбээр бичихдээ 1911 оны арванхоёрдугаар сарын 12-нд Оросын төрийн зөвлөлийн гишүүн В.И.Денисов сайд нарын Зөвлөлийн дарга В.Н.Коковцовт нууц захидал өргөн *"Оросуудын оролцоо, удирдлагаар Монголыг тусгаар тогтносон улс болгохыг санал болгожээ. Тэрхүү захидлын хуулбарыг В.Н.Коковцов Гадаад хэргийн сайд С.Д.Сазоновт ес хоногийн дараа хүргүүлэхдээ В.И.Денисовын саналыг эсэргүүцэж Монголчууд бол бие даасан улс болон оршин тогтнох"* чадваргүй гэж бичсэн бөгөөд үүнийг С.Д.Сазоновч дэмжиж 1912 оны наймдугаар сарын 17-ны онцгой зөвлөлгөөн дээр ч тэрбээр энэ саналыг тууштай хамгаалсныг тэмдэглэжээ.

Ийм байдлаар С.Д.Сазонов 1911 оны наймдугаар сарын 17-ны өдрийн Онцгой зөвлөлгөөнөөс Халх бол Хятадын бүрэлдэхүүнд өргөн эрхтэй автономит улс байх ёстой" гэсэн шийдвэрийг тууштай өмгөөлж байлаа.

С.Д.Сазоновын саналыг Оросын Худалдаа үйлдвэрийн эзэд ялакГгуяа Сибирийн хөрөнгөтнүүд Монголын зах зээлд хөнгөлөлттэй буюу гаалийн хураамжгүйгээр тус улсын түүхий эдийг хямд үнээр авах нь туйлын ашигтайг ойлгож байв. Томскийн Их Сургуулийн профессор М.И.Боголепов, М.Н.Соболев нар 1910 онд эдийн засгийн шинжилгээ судалгааны ажлаар Монголд ирж байдлыг сайтар мэдсэн учир тус улсыг Орост нэгтгэх нь ашиггүй. Харин Орос, Хятадын хооронд бамбай улс байлгаж Оросын худалдаачид Хятадуудаас илүү эрх эдлэж байхаар эцэслэн шийдвэрлэх нь зөв гэж үзэж байв. Гэтэл Монголын тухай асуудлыг зуучлах тухай Хятадын Засгийн газартай Орос улсын хийж байран хэлэлцээ мухардалд орж Бээжин Оросын зуучлах саналыг эрс няцааж Юань Шикай Нийслэл хүрээтэй хэл амаа ололцох буюу Монголыг тусгаар тогтнолоос нь татгалзуулж чадна хэмээн итгэж байв. Энэ зорилгоо хэрэгжүүлэхийн тулд Монголыг Хятадад нэгдэхийг ятгуулахаар Гүнсээноровыг халх руу илгээж байсаны сацуу Ф.А.Ларсон гээчийг нийслэл хүрээнд одуулж халх Хятадад нэгдэх нь ашигтай хэмээн лам ноёдод ухуулга сурталчилгаа хийлгэж байв.



Гэвч Нийслэл хүрээнийхэн Бээжингийн бүх саналыг эрс эсэргүүцэж улсынхаа тусгаар тогтнолоос огтхон ч татгалзахгүйгээ мэдэгдэж Оростой хэлэлцээр хийхээр шийлдвэрлэсэн байна гэдгийг Е.А.Белов холбогдох сурвалжид тулгуурлан тайлбарлажээ.

Мөн тэрбээр яг тэр үед Монгол Оросын хооронд багагүй зөрчил байсныг маш тодорхой гаргаж тавьсан юм. Энэ талаар Е.А.Белов бичихдээ Богд хаан халх, Өвөр монгол, Барга, Баруун монгол, Урианхайн хязгаарыг нэгтгэсэн Монгол улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхийг Петербургээс шургуу хүсэж байлаа. Гэтэл Хаант Оросын Засгийн газар халх баруун монгол хоёрыг нэгтгэж Хятадад автономит эрхтэй захирагдсан улс байлгахыг хичээж байв.

Хоёр этгээдийн гол маргалдагч нар нь ерөнхий консул В.Ф.Люба Да лам Цэрэнчимэд байв. Иймээс ч И.Я.Коростовецийн зөвлөсний дагуу С.Д.Сазонов ерөнхий консул Люба-д заавар өгч Да ламыг бидний итгэж болохуйц хүнээр солихыг Богдод сануул гэж мэдэгдсэн бөгөөд оросуудын шаардлагаар Богд 1912 оны долоодугаар сарын эцсээр Намнансүрэнг Сайд нарын Зөвлөлийн даргаар томилов. Гэвч Г.Цэрэнчимэд Дотоод хэргийн сайдын тушаалдаа хэвээр үлдэж урьдын адил хутагтын улс төрийн гол зөвлөх хэвээр байв. Тэрээр Хятадын талыг барьсан үзэл бодолгүй боловч Монголыг тусгаар тогтносон улс болгохыг хамгийн гол зорилгоо болгож байлаа. Монгол Хятадын асуудлыг зуучлах хэмээсэн Оросын оролдлого явцгүй болж Нийслэл хүрээний Засгийн газар Хаант Оросоос Монголын талаар баримталж буй бодлогод дургүйцлээ илэрхийлж байхад Хятадууд Монголыг тайван замаар өөрийн нөлөөндөө оруулахыг хичээх болов.

Ийм нөхцөлд С.Д.Сазонов чухал дипломат алхам хийж Бээжинтэй хэлэлцээрээ зогсоож Халхын статус ба Оросоос түүнтэй хэрхэн харилцах асуудлаар Нийслэл хүрээтэй хэлэлцээ эхлэх шийдвэр гаргав Ингээд 1912 оны наймдугаар сарын 12-т В.Н.Коковцовын удирдлагаар Хаант Оросын Засгийн газрын онцгой зөвлөлгөөн болж С.Д.Сазонов илтгэл тавьж, Хятадууд бидний оролцоогүйгээр Халхад өөрийн засаглалыг тогтоохоор найдаж байх шиг байна. Иймээс Монголын тухай асуудлыг удаашруулах нь аюултай болсон тул Орос Халхын хооронд дипломат гэрээ байгуулах нь зүйтэй. Түүний гол агуулга нь Хаант Оросын Засгийн газар, Халхын ёс тогтолцоог хамгаалж Хятад цэргийг Монголд оруулахгүй, Хятадаар монголын колоничлуулахгүй байхад оршино гэжээ. (Белов...1999.81-83)

Е.А.Белов энэхүү хэлэлцээрийн тухай бичсэн зүйл бол урьд өмнө нь Монгол, орос судлаачдын бүтээлд ер хөндөж байгаагүй хэд хэдэн шинэ асуудлыг тодруулж өгснөөрөө чухал ач холбогдолтой. Иймээс энэ талаар тогтож өгүүлье.

1912 оны Монгол-Оросын найрамдлын хэлэлцээр дөрвөн зүйлтэй байдаг. Гэтэл Хаант Оросын тал анх уул хэлэлцээрийн төслийг ердөө хоёрхон зүйлтэй бэлтгэсэн байжээ. Түүний нэгдүгээр зүйлд нь Оросын эзэн хааны Засгийн газар гадаад монголын ард түмэн өөрийн үндэсний ноёд ба засгийн эрх мэдэлтнүүдээр захируулах эрхээ хэвээр хадгалж үндэсний цэрэгтэй байж нутаг дэвсгэртэй хятад цэрэг оруулахгүй өөрийн газар нутгаа хятадаар колончлуулахгүй эрхтэйг заажээ. Хоёрдугаар зүйлд нь Жибзундамба хутагт ба халхын дөрвөн хан дээр дурдсан зүйлүүдийг зөрчсөн ямарч хэлэлцээрийг бусадтай байгуулахгүй. Орос Манжийн хооронд байгуулсан гэрээ ба түүнд хавсаргасан протоколд дурдсанчлан Оросын харьяат нар урьдын адил өөрийн эзэмшилдээ давуу эрхтэй байх болно гэжээ.

Энэхүү бэлтгэсэн төслийг 1912 оны есдүгээр сарын 3-нд С.Д.Сазонов II Николай хаанд илтгэх хуудасны хамт өргөн толилуулаад И.Я.Коростовецийг Нийслэл хүрээнд одуулж хэлэлцээр хийлгэхийг хүссэн байна. Мөн уг хэлэлцээрийн төсөл нь Монголын автономийг баталгаажуулсан улс төрийн хэлэлцээр ба Халх дахь Оросын харьяат нарын эдлэх эрхийг тодорхойлсон протоколоос бүрдэж байгааг С.Д.Сазонов танилцуулжээ. Е.А.Беловын бичсэн энэ зүйл бол урьд өмнө нь ямар ч судлаач ер сөхөж үзээгүй шинэ зүйл байсан учраас цаашид энэ сэдвээр гүнзгийрүүлсэн судалгаа хийх боломжийг улам өргөжүүлж өгч байгаа юм.



### III. МОНГОЛЫН ТҮҮХ БИЧЛЭГИЙН АСУУДЛУУД

И.Я.Коростовец 1912 оны аравдугаар сарын эхээр Нийслэл хүрээнд ирсэн тухай Е.А.Белов өгүүлээд тэр үед Монгол ноёдын дунд Оростой ойртох гэсэн эрмэлзлэл нилээд суларч байгаа тухай консул В.Ф.Люба И.Я.Коростовецэд ярьсныг тэмдэглэжээ. В.Ф.Люба ярихдаа ийм байдал бий болсон нь Хятадын ятгалгатай холбоотой, нөгөө талаар Оросын зүгээс тодорхой шийдвэр байхгүй нь нөлөөлж байна. Уг нь бүх монгол ноёд манайд захируулахад бэлэн байсан юм. Гэтэл одоо тэд Хятадтай эвлэрч Бээжингийн Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч Наянтыг Нийслэл хүрээнд ирүүлж хэлэлцээ хийх тухай ярьцгаах боллоо гэж мэдэгджээ.

И.Я.Коростовец В.Ф.Люба нар аравдугаар сарын 6-нд Нийслэл Хүрээн дэх консулын газарт Намнансүрэн тэргүүтэй сайд нарыг урьж ярилцахад Монголын эрх баригчдаас Г.Цэрэнчимэд хамгийн гол үүрэгтэй байсныг Е.А.Беловын бүтээлд дурджээ. Тухайлбал Да лам Монгол улс энэ гэрээгээр Хятадаас тусгаар тогтнохоо зөвшөөрүүлж чадах уу. Оросын протекторат болчихгүй биз гэж тэр хоёроос асуусан байна. Мөн тэрбээр манай монголд дагаар орохоо мэдэгдсэн Өвөр Монгол бусад нутгууд тухайлбал Ховд, Урианхайн хязгаар, Баргыг гэрээний төсөлд яагаад багтаагаагүй вэ. Эдгээр нутаг бол бидэнтэй адил Хятадын дарлалд сүйрч байгаа монголчууд, тусгаар тогтнолоо мөрөөдөгчөөж байгаа юм шүү гэж нэмж хэлсэн байна.

Үүний хариуд В.Ф.Люба өгүүлэхдээ Өвөр Монгол бол газар зүйн хувьд болон улс төрийн талаар Хятадтай илүү их холбоотой ба зарим талаар хятаджих байдалтай болсон юм. Харин Ховд хязгаарын тухай асуудлыг Петербургт уламжилъя гэж консул амласан байна. Энэ дагуу мөн сарын 8-нд И.Я.Коростовец Петербургт цахилгаан утас илгээж *"хэлэлцээний явц уруудах янзтай боллоо"* зөвхөн Да лам бус Намнансүрэн ч гуйвж дайвах боллоо. Энэ нь Бээжингээс Монгол ноёдыг айлган сүрдүүлэх, худал амлах зэрэг зүй бус ажиллагаа явуулж байгаагаас болж тэдний зарим нь Орост хандахаасаа цэрвэхэд хүргэж байх мэт гэж тэрбээр уг цахилгаан утсандаа тэмдэглэжээ.

Гэвч бодит байдал Хятадаас Нийслэл хүрээнд чиглэсэн бодлоготой төдий л холбоогүй харин Монголчууд Оросын тулгаж буй автономийг бус тусгаар тогтнолыг хүсэж байсан учраас хэлэлцээ мухардалд орох боллоо гэж Е.А.Белов бичсэн нь зөв юм.

Монголын Засгийн Газар хэлэлцээрт зориулж бэлтгэсэн төслөө бидэнд өглөө. Тэр төсөл нь оршил ба долоон зүйлтэй бөгөөд оршил хэсэгт нь Монгол улсын тусгаар тогтнолыг тунхагласныг нилээд түүхчлэн дурдаад Орос улс манай тусгаар тогтнолыг анх хүлээн зөвшөөрсөн гэж тэмдэглэжээ. Гэрээний нэгдүгээр зүйлд Монголын эзэн хаанаар Жибзундамбыг өргөмжилсөн тухай мөн Монгол улсын бүрэлдэхүүнд багтах нутаг дэвсгэрийн тухай өгүүлжээ. Дөрөвдүгээр зүйлд нь Орос улсын элчинг Нийслэл хүрээнд, Монголын бусад хотуудад консул суулгана гэсэн бол тавдугаар зүйлд нь Монгол дахь Оросын харьяат нар ба Орос дахь монголын харьяат нарын тухай өгүүлсэн ба долоодугаар зүйлд нь Монголын Засгийн Газар Оростой байгуулсан хэлэлцээрийн заалтад харшлахуйц ямар нэгэн гэрээ хэлэлцээр байгуулахгүйгээ илэрхийлсэн байна гэж И.Я.Коростовец 1912 оны аравдугаар сарын 15-нд Петербургт мэдэгджээ хэмээн Е.А.Белов бичсэн нь урьд өмнө нь ямар ч түүхчийн бүтээлд ер тусгаагүй цоо шинэ мэдээ юм. (Белов...1999.85)

Гэтэл Оросын төлөөлөгчдөөс бэлтгэж ирсэн хэлэлцээрийн төсөлд дурдсанаар бол Монгол улс Хятадын бүрэлдэхүүнд хэвээр үлдэж өргөн автономит эрхтэй байх бөгөөд нутаг дэвсгэр нь Халх, баруун монголоор хязгаарлагдах ёстой вэ монголын удирдагчид тэр төсөлтэй танилцаад хэрхэвч зөвшөөрөхгүйгээ эрс мэдэгджээ. Гэтэл И.Я.Коростовец өөрийнхөө төслийг эсэргүүцэхэд Г.Цэрэнчимид бусдыгаа удирдан уруу татж байна хэмээн ихэд дургүйцэж Петербургт мэдээлэхдээ Да лам биднийг үзэн ядаж Орос улс Монголыг боолчлохоор зэхэж байна хэмээн сэжиглэж монголчууд Оростой ойртохын эсрэг байна. Иймд түүнийг хэлэлцээрээс татах нь зүйтэйг Сазоновт санал болгоод Богд хутагт Да ламыг ер буруутгахгүй байна хэмээн бичжээ.

Оросын төлөөлөгчид Монголын төслийг ер хүлээж авахгүй байсан учир Нийслэл Хүрээний Засгийн Газар оршил ба таван зүйлтэй төсөл шинээр бэлтгэж өгсөн бөгөөд



И.Я.Коростовец түүнийг Петербург руу С.Д.Сазоновт илгээсэн байна. Д.Сазонов энэхүү төсөл нь ДИУ-ын нутаг дэвсгэрийг үл хөндөх зарчмыг зөрчиж буй учир хүлээн авах боломжгүй гэж цахилгаан утсаар хариу өгчээ.

Мөн хэлэлцээрийн үед гарсан бас нэг маргаан бол Оросын төсөлд *"Гадаад Монгол"* Нийслэл хүрээнийхний төсөлд *"Монгол улс"* хэмээх үгийг цаашид хэрэглэхээр бичсэн нь ирээдүйн Монголын хил хязгаарын тухай зарчмын маргаан үүсгэхэд хүрч болзошгүй байсан юм. Гэвч *"Монгол улс"* гэдэг үгийг хэлэлцээрт оруулья хэмээн тохирсон бөгөөд энэ үгийг Оросууд *"Гадаад Монгол"* гэж ойлгох ёстой гэж үзэж байв. Хэлэлцээр ба хавсралт протоколд гарын үсэг зурсан өдөр И.Я.Коростовец, С.Д.Сазоновын шаардсаны дагуу Монголын Засгийн газарт анхааруулж *"Гадаад Монгол"* гэдэг үгийг *"Монгол Улс"* хэмээх үгээр солихыг зөвшөөрөхийн сацуу Монголд олгосон автономит эрхийг ямар нутаг дэвсгэр дээр дэлгэрүүлэн хэрэглэхийг заан тодорхойлох эрхтэйгээ илэрхийлье" хэмээн мэдэгджээ. (Сборник...1913.4) Үүний дараа Хаант орос өөрийнхөө төлөвлөсөн төслийг Монголоор зөвшөөрүүлж чадсан тухай Е.А.Белов бичсэн байна.

Энэхүү хэлэлцээрийн тухай Е.А.Беловын бичсэн зүйл нь хэдийгээр урьд өмнөх түүхчдийн бүтээлд дурдсан зүйлтэй ерөнхийдөө адилавар боловч бусад судлаачдын огт тодруулаагүй байсан зүйлийг шинээр мэдээлж байгаа юм. Тухайлбал, энэхүү хэлэлцээрийн бэлтгэл болгож Монголын удирдагчид анхны удаад оршил ба долоон зүйлтэй, хоёрдахь удаад оршил ба таван зүйлтэй хоёр төсөл бэлтгэж хэлэлцүүлсэн боловч өөрийнхөө чухам зорилгодоо буюу Монгол нь Өвөрмонгол, Баргыг өөртөө нэгтгэсэн тусгаар улс болгох гэсэн чармайлтаа Оросын төлөөлөгчдөөр зөвшөөрүүлж чадаагүйг болон Монгол нь өөрийнхөө нутгийн хил хязгаарыг ч тодорхойлох эрх олж аваагүйг дурджээ.

Энэ дашрамд тэмдэглэхэд 1912 оны дундуур Монголын удирдагчид Орос улстай хэлэлцээр байгуулахаар эхлээд долоон зүйлтэй эх бэлтгэснийг Оросын төлөөлөгчид эрс зөвшөөрсөн учир дахин боловсруулсан таван зүйлтэй эхийг олж судалбал нэн хэрэгтэй билээ. Эдүгээ Орос болон манай түүхчдийн судалж байгаа хэлэлцээр буюу гэрээ нь дөрвөн зүйлтэй бөгөөд гарын үсэг зурж баталсан жинхэнэ эх юм. Энэ нь түрүүчийн хоёр эхээсээ хэр зэрэг өөрчлөгдсөнийг харьцуулан тодруулбал тухайн үед Монголын удирдагчид гадаад бодлогодоо ямар байр суурьтай байсныг нэмэн тодруулахад зохих дөхөм болох нь лавтай.

Энэхүү хэлэлцээрээр Орос улс 1881 оны хоёрдугаар сард Санкт-Петербургт Орос Манжийн хооронд байгуулсан гэрээгээр *"Монголд оршин суудаг Оросын харьяат нар татвар төлөхгүйгээр худалдаа хийх эрхтэй"* (Орос...2001.74) болсноо улам бататгаж хэлэлцээрт хавсаргасан протоколын 2 дугаар зүйлд: *"Их Орос улсын харьяат хүн нар хуучин ёсоор ... элдэв зүйлийн эд таваар оруулах ба гаргах бас эд таваарыг цаазлагдахгүйгээр худалдах эрх буй бөгөөд цөм гааль түрээс ба өөр алба татвар өгөхгүй"* (Монголын...1982.176) гэж заасан юм. Үүнээс гадна энэхүү хэлэлцээрээр Хаант Оросын харьяат нарт олгосноос илүү эрхийг Хаант Оростой зөвлөхгүйгээр *"гадаад олон улсын хүн нарт ... өгч үл болно"* (Монголын...1982.175) гэдгийг Монголын Засгийн газарт тулган хүлээлгэсэн билээ.

Дээр дурдсанаа хураангуйлж хэлэхэд энэхүү хэлэлцээр нь Монголын Засгийн газарт мэдэгдэхүйц нааштай шийдвэр гаргаж чадаагүй боловч түүхчид энэ талаар чимээгүй өнгөрсөн байдаг. Харин судлаачдын зарим нь Монгол Оросын хэлэлцээр нь *"Монголын түүхэнд давшилттай"* (Пунцагноров...1955,1956) зүйл болсон мэтээр тайлбарлаж байсан нь гагцхүү Оросын түрэмгий бодлогыг шүүмжилбэл буруудаж болзошгүй хэмээн болгоомжилсных буй за. Тухайн үед Монголын удирдагчид энэхүү хэлэлцээрээр Монголын эрх ашигт нааштай зүйлийг төдий л олж авч чадахгүй ажээ хэмээн Нийслэл хүрээний эрх баригчид ойлгож ухаарсан учраас Оросын төслийг зөвшөөрөхгүй байжээ. Гэвч хятад цэрэг Монгол руу довтлохоор хөдөлчихлөө шүү гэсэн И.Я.Коростовецийн сүрдүүлгийг үнэмшиж арга буюу гарын үсэг зурсан нь маргаангүй ээ.



Оросын засгийн газар ч өөрийнхөө саналыг монголчууд хүлээн авна гэдэгт эргэлзэж байсан бололтой. Тиймээс ч 1913 оны долдугаар сарын эхээр И.Я.Коростовецийг Петербургт очиход С.Д.Сазонов түүнийг хүлээн авч уулзахдаа *"Таяаж монголчуудаар тэрхүү хэлэлцээрт гарын үсэг зуруулж чадав. Монголчууд бол ямар ч ухуулга ятгалгыг хайхардаггүй зэрлэгүүд гэдгийг нь би Монголын элч төлөөлөгчид энд /1911 онд З.Л/ ирэхэд мэдсэн юм хэмээн гайхаж байв"* (Коростовец...2004.379).

Энэхүү хэлэлцээр түүний хавсралтын бараг бүх заалт нь Монголын зах зээлд буюу эдийн засагт Орос улс хэмжээ хязгааргүй ноёрхох эрхээ баталгаажуулсаны сацуу улс төрийн хувьд үл тоож ихэмсэглэхээ нотолсон юм. Жишээлбэл: хавсралтад заасны дагуу Оросын засгийн газар өөртөө ашигтай хэмээн үзвэл өөрийн консулын газрыг Монголын хаана ч байгуулах бүрэн эрхтэй атлаа Монгол улс хэрэв төлөөлөгчийн газар буюу консул Оросын нутагт байгуулахад хүрвэл зөвхөн *"хилийн ойрхон мужид төлөөний хүн"* (Монголын...1982.177) суулгахыг Оросын тал зөвшөөрчээ.

Тус хэлэлцээрээр Орос улс Монголын зах зээлд онцгой эрхтэй байхаа Монголд тулган хүлээлгэсний сацуу бусад улстай ямар нэгэн гэрээ хэлэлцээр байгуулахад хүрвэл Орост *"олгосноос үлэмж (илүү З.Л) эрх өгч үл болно"*. Мөн түүнчлэн энэхүү хэлэлцээр түүний хавсралтад *"заасан зүйлүүд Орос улстай урьдаар зөвлөлдсөн нь бус болвоос хэрхэвч бээр халж эвдэж үл болно"* Оросын харьяат нар бараа бүтээгдэхүүн Монгол улсад оруулах, гаргахад гааль хураалгахгүйг худалдаа хийхэд татвар төлөхгүй болсон юм. (Монголын...1982.176). Гэтэл тэр үед тус улсын санхүү тун тарчиг байсан учир мөн хуримтлал бий болгохын тулд 1912 оноос эхлэн экспорт, импортын бүх зүйлээс гааль хурааж худалдаа, үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч хэн боловч татвар төлөх хэд хэдэн дүр батлан дагаж шийтгүүлж байлаа. Мөн тариалан уурхай бүхий гадаад, дотоодын харьяат бүх иргэнээс татвар хурааж байв. Гэтэл Оросын харьяат нар Монгол улсын иргэнээс илүү давуу эрх эдлэх болсон нь бүх монголчуудад Оросын үнэн дүр төрхийг сайтар харуулж өгчээ. Дээрхи хэлэлцээр байгуулсаны дараа гадаадын харьяат нар оросуудтай барьцаж гааль татвар төлөхөөс эрс татгалзсан учир Монголын засгийн газар 1913 оны хавраас эхлэн импортын бүх зүйлд гааль ноогдуулахаа цуцлаж Оросын харьяат нараас бусад бүх хүн худалдаа эрхэлбэл гадаад дотоодын иргэн гэхгүйгээр таван хувийн татвар төлж байхаар хуульчилжээ. (Зарлигаар...1995.65)

Монголын удирдагчид Орос улсын сүрдүүлэн тулгасан болзлыг тухайн үед хүлээн авахаас өөр гарц байсангүй. Гэтэл уул хэлэлцээр яваандаа Монгол Оросын харилцаанд ихээхэн сөрөг үр дагавар учруулж болзошгүйг Коростовец сайтар ухаарч байсан учир Засгийн газартаа тун тодорхой учирлан уламжилсаныг Оросын эрх баригчид анхаарч ёс төдий буулт хийсэн дүр үзүүлж *"Хиагтаас баруун талын нутгаар монгол худалдаачид Орос руу түүхий эд нэвтрүүлбэл гааль хураалгахгүй"* гэж шийдвэрлэснийг уул хэлэлцээрт гарын үсэг зурсны дараахан Коростовец Монголын засгийн газарт тусгай нотоор мэдэгджээ. (Монголын...1982.179-180) Энэ нь Орос улс гэнэн цагаан монголчуудын "толгойг эргүүлэх" зорилготой заль мэх байсныг монголын эрх баригчид ойлгож Оросын хэт давуу эрхийг бага боловч хязгаарлахыг байнга хичээж байжээ. Жишээ нь: 1913 оны арванхоёрдугаар сарын арванд Т.Намнансүрэн Орост айлчилж байхдаа тус улсын ГГЯ-ны тэргүүн сайдад албан бичиг өргөн илгээж Монголын санхүү төсөв хөтө тарчиг байгааг дурдаад гол орлого нь алтны уурхайгаас хураах татвар хятад худалдаачдын импорт, экспортын гааль, худалдааны татвараас бүрдэж байна. 1912 онд манай хоёр улсын хооронд байгуулсан хэлэлцээрийн ёсоор Оросын харьяат нараас Монгод нэвтрүүлэх Монголоос гаргах зүйлээс болон Оросын харьяат нараас ямар ч гааль татвар авахгүй байгаа юм. Үүний улмаас *"хэдэн арван сая цаас"* монголын төсөвт орохгүй байна. Иймд уул гэрээний заалтыг өөрчлөх талаар зөвлөн хэлэлцсэн юм. Үүнээс гадна удахгүй эхлэх Орос, Хятад, Монгол гурван улсын хэлэлцээрийн үед *"Хятадын засгийн газраас худалдааны гааль ба алба татаар (татвар З.Л) өгөх эсэхийг хэнд ч онц эрх олгохгүй нэгэн адил шийтгэхийг хүсэх нь магад тул"* (УТА. А 4-1-190) миний хүссэнийг нэн даруй хэлэцвээс зохих болов



уу хэмээн толилуулсан боловч түүнд нь Оросын ГЯЯ ямар ч хариу өгөөгүй байна. Өөрийнх нь энэхүү саналыг Орос улс хэрхэвч хүлээн авахгүйг Т.Намнансүрэн гадарлаж байсан боловч хэдхэн сарын дараа эхлэх Хиагтын гурван улсын хэлэлцээрийн үед Орос улс Монголыг ДИУ-аас өмгөөлж арай нааштай хандаарай хэмээн сануулга болгох үүднээс уул нотыг толилуулсан байж магадгүй ээ.

1914 оны намар Хиагтад эхэлсэн гурван улсын хэлэлцээрийн төгсгөл рүү хэдэн өдөр дараалан Хятадын харьяат нар Монголд хураалгах гааль, татварын тухай нилээд хурц маргалджээ. Тэгэхдээ Оросууд Монголд гааль татвар төлөх тухай асуудлыг ер хөндсөнгүй зөвхөн хятад худалдаачид монголд хураалгах гааль татварыг л ярьцгаажээ. Энэ нь Орос Хятадын төлөөлөгчид эцнээ хуйвалдсаны нотолгоо ч байж магадгүй. Оросын төлөөлөгчдийн саналаар бол хятадууд монголд үйлдвэрлэл эрхэлбэл ямар ч татвар хураамж ноогдуулахгүйг монголын төлөөлөгчид зөвшөөрөх ёстой байлаа. Гэтэл хятадын төлөөлөгчид монголын төлөөлөгчдийн саналыг ч сонсолгүйгээр хэлэхдээ хятад худалдаачдыг гааль татварын аль алианаас нь чөлөөлүүлэх саналтайгаа мэдэгдэв. Үүнийг нь Монгол Оросын төлөөлөгчид эсэргүүцэхэд хятадын төлөөлөгчид дахин хоёр удаа мэдэгдэл хийж эхний саналдаа Монголд худалдаа эрхэлж буй хятадуудад ердөө 2,5 хувийн татвар ноогдуулахыг зөвшөөрвөл бид Засгийн газартаа мэдэгдэж хариу өгье гэжээ. Гэвч Монгол Оросын төлөөлөгчид үүнийг мөн л эрс эсэргүүцсэнд дараа нь дахин өөр санал дэвшүүлж Хятадын харьяат нарын монголд борлуулах архи, тамхинаас 10 хувь бусад зүйлээс 5 хувийн татвар төлө. Тэгэхдээ энэ хэмжээг цаашид хэрхэвч өөрчлөхгүйгээ *“албаны бичгээр батлах хэрэгтэй”* (Хятад...1999.253) гэжээ. Монгол, Оросын төлөөлөгчид үүнийг хүлээн авсан бөгөөд энэ нь Хятадын харьяат нарын хураалгах таварын хэмжээ Монгол улсын иргэдтэй яг ижил байлаа. (Хятад...1999.275)

Энэхүү хэлэлцээрийн үед Оросын төлөөлөгчид, Монголын харьяат нар хятад руу бараа нэвтрүүлэхэд гаалийн татвараас чөлөөлж борлуулах зүйлээс нь хятад иргэдтэй адил хэмжээний татвар төлүүлж байхыг санал болгосныг монголын төлөөлөгчид дэмжсэн байна. (Хятад...1999.260) Гэвч хятадын төлөөлөгчид энэ бол монголчууд орос худалдаачдын барааг өөрийнхөө нэрээр Хятадад нэвтрүүлэх гэсэн бодлого хэмээн мэдэгдэж татгалзжээ. (Хятад...1999.256,260)

Эцэст нь тэмдэглэхэд Монгол судлаач эрдэмтэн Е.А.Беловын мэдээлж байгаагаас үзвэл Хаант орос улсын бэлтгэсэн дээрх хэлэлцээрийн анхны төсөл, мөн Монголын засгийн газрын бэлтгэсэн хоёр төслийн аль алиныг олж хэвлэн нийтлэх ба тэдгээрийг нарийвчлан судлах явдал өнгөрсөн зууны Орос Монголын харилцааны түүхийг улируулан шинжлэхэд олон талын учир холбогдолтойг түүхчид анхаарах нь чухал байна.

1912 онд Монгол Оросын хооронд байгуулсан дөрвөн зүйлт хэлэлцээр, түүнд хавсаргасан 17 зүйл бүхий “тусгай гэрээ бичиг”-ийг манай түүх бичлэгт судалсан байдлыг хураангуй хөндсөн эл өгүүллийг уншигч эрхэм абугай Та хэрэв толилбоос өөрийнхөө мэргэн санаа бодлыг олдой, мөхөс надтай хуваалцахсан болов уу хэмээн горилж байгаагаа эцэст нь тэмдэглэе.

#### Abstract

The writing “Historiography of Mongolia –Russia agreement of 1912” briefly discusses the studies by historians of the agreement which was reached between Mongolia and Russia in November of 1912.

#### Ном зүй

1. Балдоо...1999 - Балдоо Б. Богд хаант Монгол улс ба Орос, Хятадын их гүрний бодлого — *Монголын тусгаар тогтнол ба Орос, Хятадын хүчин зүйл* УБ.1999
2. Батсайхан...2005 - Батсайхан О. Монгол үндэстэн бүрэн эрхт улс болох замд УБ.2005



### III. МОНГОЛЫН ТҮҮХ БИЧЛЭГИЙН АСУУДЛУУД

3. Белов...1999 – Белов Е.А. Россия и Монголия (1911-1919) М.1999
4. Болд...2008 – Болд Р. Монголын тусгаар тогтнол ба Америкийн Нэгдсэн Улс (1910-1973) УБ. 2008
5. БНМАУ...1955 – БНМАУ-ын түүх УБ. 1955
6. БНМАУ...1966 – БНМАУ-ын түүх. *Засварлаж нэмсэн хоёр дахь удаагийн хэвлэл* УБ. 1966
7. БНМАУ...1968 – БНМАУ-ын түүх *Дэд боть 1604-1917* УБ. 1968
8. БНМАУ...1984 – БНМАУ-ын түүх *Нэмж засварласан гурав дахь хэвлэл* УБ. 1984
9. Дамдинсүрэн...1982 – Дамдинсүрэн Ц., Лувсандэндэв А. Орос-Монгол толь *Нэмж зассан хоёрдугаар хэвлэл* УБ. 1982
10. Дэндэв...1934 – Дэндэв Л. Монголын товч түүх. *Дөдүгээр дэвтэр* УБ 1934
11. Зарлигаар...1995 – Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг *Монголоос кирилл бичигт буулгасан О.Батсайхан, З.Лонжид, Ч.Хажидсүрэн* УБ 1995
12. Коростовец...2004 – Коростовец И.Я. От Чингис хана до Советской республики. *Краткая история Монголии с особым учетом новейшего времени* УБ 2004
13. Лхамсүрэн...1995 – Лхамсүрэн Б. Монголын гадаад орчин, төрийн тусгаар тогтнол УБ 1995
14. Магсаржав...1994 – Магсаржав Н. Монгол улсын шинэ түүх УБ 1994
15. Мешеряков...1959 – Мешеряков М.В. Очерк экономического сотрудничества Советского Союза и Монгольской Народной Республики М.1959
16. Монгол...2003 – Монгол улсын түүх. Тавдугаар боть. (XX зуун) УБ 2003
17. Монголын...2003 – Монголын ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл. *Баримт бичгийн эмхтгэл (1900-1914)* Эмхтгэсэн А.Очир, Г.Пүрэв УБ 1982
18. Орос...2001 – Орос Хятадын гэрээ хэлэлцээрүүдийн эмхтгэл. Нэгдүгээр хэсэг (1689-1949он) *Эмхтгэсэн М.Батчимэг* УБ 2001
19. Пунцагноров...1955 – Пунцагноров Ц. Монголын автономит үеийн түүх УБ 1955
20. Сборник...1913 – Сборник дипломатических документов по монгольскому вопросу. СПб. 1913
21. Тойнби...2007 – Тойнби А.Ж Түүх судлал эмхтгэл *Орчуулсан Х.Лхамдорж* УБ 2007
22. УТА...Үндэсний төв архив
23. Хятад...1999 – Хятад, Орос, Монгол гурван усын 1915 оны Хиагтын гэрээ. Өдөр тутмын тэмдэглэл. *Баримт бичгийн эмхтгэл. Эмхтгэж иайлбар бичсэн О.Батсайхан* УБ 1999
24. Чимитдоржиев...1987 – Чимитдоржиев Ш.Б. Россия и Монголия М. 1987
25. Ширэндэв...1971 – Ширэндэв Б. Монгол ардын хувьсгалын түүх УБ 1971